

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Н. Лувсанчүлтэм

ХЯТАД: ДАЙН БА ЭНХИЙН АСУУДАЛ

Социалист ертөнцийн уйгагүй тууштай тэмцэл, дэлхийн энхийг эрхэмлэгч бүх хүчний чармайлтын үрээр 70-аад онд олон улсын харилцаанд намжмал байдал бий болж, энх тайвнаар зэрэгцэн орших зарчим батжин хэрэгжиж эхэлсэн билээ. Олон улсын байдалд ийнхүү нааштай өөрчлөлт гарах үйл явцад өрнөдийн улс төрийн зарим зүтгэлтний бодит хандлага ч тодорхой үүрэг гүйцэтгэсэн нь мэдээж юм.

Гэтэл 70, 80-аад оны зааг дээр империалист, юуны өмнө АНУ-ын хамгийн харгис бүлгийнхэн нийт хүн төрөлхтний амин чухал эрх ашгийн эсрэг балмад түрэмгий бодлого явуулж, энх тайвны үйлст заналхийлж эхлэв. Рейганы засаг захиргаа, түүний НАТО-гийн холбоотнууд зэвсгээр хөөцөлдөх явдлаа улам даамжруулж үй олноор хөнөөгч нейтрон болон бинар, химийн зэвсгийг шинээр үйлдвэрлэх, өрнөд Европт америкийн дунд зайны тусгалтай пуужин-цөмийн зэвсгийг олноор байрлуулах, цөмийн «хязгаарлагдмал дайн» хийх бодлогыг илт зарлаж намжмал байдлын процессыг тасалдуулан, хүн төрөлхтнийг «хүйтэн дайны» үед эргүүлэн оруулахыг санаархаж байна. Энэ зорилгоор тэд хурцадмал байдлыг намжаах үндэс болсон зарчим, хэлэлцээнээс татгалзаж, «зөвлөлтийн цэргийн аюул» гэгч шуугиан дэгдээж «Афганистан, Польшийн эрх ашгийг хамгаалах» гэдэг хуурамч зүйлээр халхавчилж, улс түмний энх тайван, аюулгүй байдлын өмөг түшиг болсон ЗХУ-ыг илт дайсагнах аюултай замд орлоо. Түүнчилэн тэд дэлхийн янз бүрийн бүс нутаг дахь хурцадмал байдлыг зохицуулахад элдвээр саад тотгор учруулж, мөргөлдөөний шинэ шинэ голомтыг бий болгож байна.

Олон улсын империализмын энэ түрэмгий дайнч бодлого явууллагыг дэмжин дэвэргэхэд Хятадын өнөөгийн эрх баригчдын социализмын эсрэг их гүрний жанжлах бодлого, хамгийн идэвхитэй үүрэг гүйцэтгэж байна.

Тэд империалист түрэмгий хүчинтэй ойртон сүлбээлдэхийн хувьд «их залуурчаасаа» зарим талаар давж, үйл ажиллагааныхаа гол цохилтыг социалист хамтын нөхөрлөлийн орнууд юуны өмнө Зөвлөлт Холбоот Улсын эсрэг улам бүр хандуулж байна. Тэд «хоёр хэт их гүрэнтэй тэмцэх» лоозонгоо орхиж, АНУ, НАТО-гийн бусад орны хамаг хүчийг ЗСБНХУ-ын эсрэг хандуулж нэгдмэл фронтоор тэмцэх явдлыг тэргүүн зорилгод дэвшүүлж байна.

Бээжингийнхний гадаад бодлогын энэ чиг шугам нь маогийн «гурван ертөнцын онол» гэгчид тулгуурлаж байна.

1977 оны 10-р сарын 22-нд Дэн Сяопин Франс Пресс агентлагийн сурвалжлагчийн асуултад хариулахдаа: «Зөвлөлт Холбоот Улсын дэлхийг хамарсан цэрэг стратегийн төлөвлөгөөг таслан зогсоох хэрэгтэй бөгөөд энэ үйлсэд бүх гуравдахь, хоёрдахь болон тэрч байтугай нэгдэх ертөнц, өөрөөр хэлбэл Америкийн Нэгдсэн Улс оролцоно гэж би найдаж байна» гэж мэдэгдсэн билээ. Өнгөрсөн дөрвөн жил гаруйн хугацаанд Хятадын удирдагчид «ЗХУ-ын эсрэг нэгдмэл өргөн фронт» байгуулах

зорилгоор Өрнөдийнхнийг зулгадаж зөвлөлтийн эсрэг, социализмын эсрэг хорт явууллагаа улам бүр гааруулж ирлээ. Үүний гол зорилго нь зөвлөлтийг эсэргүүцэх бодлого явууллагынхаа шан болгож өрнөдийн гүрнүүдээс орчин үеийн зэр зэвсэг, техник, санхүү эд материалын тусламж авч 2000 он гэхэд БНХАУ-ыг «хүчирхэг милитарист гүрэн» болгож улмаар бээжингийн жанжлах санаархлыг хязгаарлагч гол хүч болсон ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн орнуудыг империалист болон хөгжиж байгаа орнуудтай хүч хавсран, болж өгвөл АНУ-ын цэргийн хүчээр дарахад оршиж байна. Чингэвэл уг мөргөлдөөнд сульдаж доройтсон АНУ-ыг хазаарлан дарж дэлхийд хятадын ноёрхлыг тогтоох бололцоо олдоно гэж горьдож байна.

ХКН-ын XI их хурал дээр Хуа Гофэн «ЗСБНХУ-ын эсрэг эвлэршгүй тэмцлийг «өнө удаан хугацаанд» үргэлжлүүлэх зорилгыг дэвшүүлсэн билээ.

Тэр ч учраас хятадын эрх баригчид хоёр орны харилцааг хэвийн болгоход чиглэсэн Зөвлөлт Холбоот Улс, ЗХУКН-ын аливаа бүх тодорхой санаачлагыг жадлан эсэргүүцсээр ирлээ. Үүнд 1971 онд хоёр орны харилцаанд хүч үл хэрэглэх гэрээ байгуулах, 1973 онд харилцан үл довтолох гэрээ байгуулах, түүнчилэн янз бүрийн салбарт зөвлөлт-хятадын хамтын ажиллагааг сэргээх, 1978 онд энх тайвнаар зэрэгцэн орших үндсэн дээр ЗСБНХУ, БНХАУ-ын харилцааны зарчмуудын тухай хамтарсан баримт бичгийг боловсруулах зэрэг сайн санааны олон чухал саналыг зөвлөлтийн тал дэвшүүлснийг дурдаж болно. Гэтэл Хятадын удирдагчид ЗХУ-ын эдгээр энх тайванч санаачлагыг ойшааж үзээгүйгээр барахгүй 1950 онд байгуулагдсан ЗСБНХУ, БНХАУ-ын найрамдал, холбоо, харилцан туслах тухай гэрээний хугацааг цаашид сунгахгүй байх шийдвэрийг 1979 оны 4-р сард гаргасан юм.

МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю.Цэдэнбал 1976 онд хэлэхдээ, «Маогийнхан социализмыг дайсагнагч хүчний хувьд дэлхийн социализмын эсрэг тэмцэх нэгдмэл фронт байгуулахын тулд арьсны үзэлт фашист бүлгийнхэн, эрээ цээрээ алдсан харгисууд империализмын түрэмгий хүчинтэй илэрхий сүлбээлдэж байна. Маоизм ингэж империализмын бэлтгэл хүч, шууд хань хамсаатан болж байна» гэж дүгнэсэн билээ.

БНХАУ-ын өнөөгийн удирдагчдын улс төрийн чиг бодлогын мөн чанар нь дайн ба энхийн асуудал дээр бүр ч тодорхой илэрч харагдаж байна. «Дайн дажин бол хүний нийгмийн хэвийн оршин тогтнох байдал юм. Энх цаг дайнд шилжих нь хавар улирч зун болохтой адил ердийн үзэгдэл юм» гэж номлодог байсан маогийн үзэл санааг хятадын өнөөгийн эрх баригчид өвлөн үргэлжлүүлж байна. Дэлхийн дайн, нэн ялангуяа халуун цөмийн мөргөлдөөн гарах нь зайлшгүй гэж илтээр зарлаж, дайн дажныг илэн далангүй сурталчилж байгаа бараг цорын ганц орон бол БНХАУ юм. ХКН-ын XI их хурал (1977 онд), БХАТХ-ын чуулган (1979 онд) дээр хятадын удирдагчид «дайны хүчин зүйлс нэмэгдэж байна», «дайн бол энх цагийн хоёр үеийн хооронд заавал тохиолдох үзэгдэл» мөн гэж албан ёсоор мэдэгдэж байв.

Даян дэлхийн бүх улс түмэн энх амгалан аж төрөн амьдрахын төлөө эрчимтэй тэмцэж байхад Хятадын эрх баригчид дайн дажныг уриалан сурталчлаж бүх нийтийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, зэр зэвсэг, ялангуяа цөмийн зэвсгийг хураах, түгшүүртэй голомтуудыг намжаан зохицуулах зэрэг олон улсын нэн чухал тулгамдсан асуудлуудыг нааштай шийдвэрлэхэд чиглэсэн аливаа бүх хүчин чармайлтыг сөргөн эсэргүүцсээр байна.

Бээжингийн стратегид жанжлах зорилгодоо хоёр системийн зөрчлийг ашиглахын тулд олон улсын байдал хичнээн их түгшүүртэй болох тусам «хоёр хэт их гүрэн» хоорондоо цөмийн мөргөлдөөн хийх нөхцөл төдий чинээ ихээр бүрдэнэ гэж үзэж байна. Тэр ч учраас ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн эсрэг АНУ болон түүний НАТО-гийн холбоотнуудыг, Ази, Африк, Латин Америкийн орны ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийн эсрэг АСЕАН-ын улсууд, Араб, Африк, Латин Америкийн фашист харгис дэглэмүүдийг турхирсаар байна. «Хоёр барын тулалдахыг уулан дээрээс ажиглаж, аль дийлдэж сульдсаныг нь олзлож авах хэрэгтэй» гэдэг эртний хятадын номлолыг гадаад бодло- гынхоо нэг гол зарчим болгосоор байгааг энд дурдахад яг таарах юм.

Хятадууд дэлхийг ноёрхох материаллаг бааз байгуулах алс хэтийн стратегийн зорилготой «дөрвөн шннэчлэлээ» хэрэгжүүлэх санхүү, шинжлэх ухаан-техникийн хэрэгслийг зөвлөлтийн эсрэг бодлогоо эрчимжүүлсний хариу шан болгон олж асах гэж горилсоор байна. Бээжингийн «дөрвөн шинэчлэлийн» зорилгыг БНХАУ байгуулагдсаны 29 жилийн ойд зориулан «Хунци» сэтгүүлд нийтэлсэн өгүүлэлд: «Ирээдүйн их дайн эхлэхэд түүнд бүх талаар бэлэн байхаар бид бодож бэлтгэх ёстой. Ийм хамгийн сайн бөгөөд хамгийн бүрэн бэлтгэл бол дөрвөн шинэчлэлийг хэрэгжүүлэх явдал юм» гэж тодорхойлж байв. Энэ үүднээс хятадын удирдагчид улс орноо өвч цэрэгжүүлэх, зэвсгээр юуны өмнө пуужинт цөмийн болон хүмүүсийг үй олноор хядах шинэ шинэ төрлийн хөнөөлт хэрэгслээр хөөцөлдөх явдлыг тэргүүн зэрэгт тавьж байна. Тийм ч учраас БНХАУ-ын эрх баригчид цөмийн дайны аюул заналыг сэрэмжлэн зайлуулах, зэвсгээр, нэн түрүүнд цөмийн зэвсгээр хөөцөлдөх явдлыг таслан зогсооход чиглэсэн ЗХУ, социалист болон энхийг эрхэмлэгч хүч- ний тууштай тэмцлийг эсэргүүцэж зэвсэг хураах, үүний дотор цөмийн зэвсгийн аюул заналыг намжаахад чиглэсэн олон улсын үлэмж чухал гэрээ хэлэлцээрүүдийн ганцад нь ч нэгдэн оролцохыг хүсэхгүй байна.

Ийм нөхцөлд хятадын жанжлагчидад орчин үеийн зэр зэвсэг техник, технологи нийлүүлэх империалист гүрнүүдийн бодлого бүр ч аюултай юм. Гэсэн ч Хятадыг хэзээ ямагт зөвхөн ЗХУ болон социалист бусад орны эсрэг хандуулж, харин өөрсөддөө гэм халгүй байлгаж болох мэтээр өрнөдийнхөн ойлгож байгаа нь ямар ч баталгаагүйгээр барахгүй, харин эргэж тэдэндээ лай болох бүрэн үндэслэлтэйг өрнөдийн эрүүл соргог хүч ухамсарлан болгоомжилсоор байна. Одоогоор социализм, энх тайван, үндэсний эрх чөлөөний хүчийг хамтран эсэргүүцэх сонирхол Бээжин, Вашингтон хоёрыг холбож байгаа болохоос биш, алс ирээдүйд хятад ба империстуудийн их гүрний жанжлах стратегийн зорилго зайлшгүй мөргөлдөнө гэдгийг капиталист ертөнцийн төрийн эрх баригч зарим хэсгүүд ч ойлгож байна. Гэлээ ч гэсэн хятадын удирдагчид империалист хамгийн харгис хүчинтэй цэрэг-улс төрийн талаар сүлбээлдэн бүх нийтийн энх тайван, аюулгүй байдлыг сахин бэхжүүлэхийн эсрэг зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг улам дэвэргэж империалист харгис хүчний түрэмгий явууллагад шууд туслалцаж байгаа нь бүр ч аюултай хэрэг юм.

Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх гол хэрэглүүр болсон Нэгдсэн Үндэстний Байгууллагад хууль ёсны эрхээ сэргээснээс хойшхи 10 гаруй жилийн хугацаанд БНХАУ-ын төлөөлөгчид тус байгууллагын Дүрэмд заасан хойч үеийг дайн дажны гай гамшгаас сэрэмжлэн хамгаалах гол зорилгыг хэрэгжүүлэхэд тус дөхөм болох нааштай ганц ч алхам хийсэнгүй. Харин ч дайны аюулыг няцаахад чиглэсэн НҮБ-ын шийдвэрийг бүдүүлгээр зөрчин, Ази, Африк зэрэг бүс нутгийн харгис дэглэмд зэр зэвсэг нийлүүлж, тэдгээр районы ард түмний шударга тэмцлийг нухчин дарагчдын үүрэг гүйцэтгэж байна.

«Бид дэлхийн бөмбөрцгийг эзэмших ёстой. Дэлхийн бөмбөрцгийг гартаа оруулж хүчирхэг гүрэн байгуулах хэрэгтэй» гэсэн Маогийн заалтыг Бээжингийн өнөөгийн удирдагчид хэлбэрэлтгүй мөрдөн бусдын газар нутгийг хүчээр булаан авч өөртөө нэгтгэх санаархлаа үргэлжлүүлж, сүүлийн 30 гаруй жилийн дотор хөрш зэргэлдээ орнуудын нутагт байнга өнгөлзсөөр ирэв. Бээжин өнөөдөр БНХАУ-ын 9,6 сая кв км нутаг дээр хөрш орнуудын 10 сая гаруй кв. км нутгийг хавсарган нийлүүлэх гэж нэг бус удаа оролдсоныг хэрэг явдал гэрчлэж байна.

Нөхөр Ю.Цэдэнбал Японы «Асахи» сонины сурвалжлагчийн асуултад хариулахдаа: «Хөрш орнуудынхаа хувьд бээжингийн баримталж байгаа их гүрний түрэмгийлэн эзлэх чиг шугам Хятад, Монголын хоорондын харилцаанаас харагдаж байгаа юм» гэж тэмдэглэсэн билээ.

Манай улсын талаар баримталж байгаа Хятадын өнөөгийн бодлого нь эртний хятадын эзэн хаад болон Мао Зэдунаас өвлөж авсан эзлэн нэгтгэх чиг шугам хэвээр байна. Иймэрхүү бодлого юунд хүргэж болохыг 1979 оны хоёрдугаар сард БНСВУ-ын эсрэг хийсэн хятадын түрэмгийлэл дэлхий дахинд тодорхой харуулсан юм.

Хятадын жанжлагчид социалист Вьетнамын аюулгүй байдалд одоо болтол янз бүрийн хэлбэрээр заналхийлж, ардчилсан Кампучи, Лаосын эсрэг бузар өдөөн хатгалга хийж тэдний дотоод хэрэгт бүдүүлгээр оролцсоор байна. Энэ жигшүүрт ажиллагаандаа АСЕАН-ын гишүүн зарим орныг татан оруулахын тулд янз бүрийн шахалт даралт үзүүлсээр байна.

Бээжингийнхэн ардчилсан Афганистаны эсрэг империалист харгис бүлгийнхэнтэй хуйвалдан зарлаагүй дайн хийсээр байна.

Энэ бүхэн нь Хятадын маоист эрх баригчдын хувьд шинэ зүйл биш юм. Дэлхийн II дайны дараа Ази тивд үүссэн 30 удаагийн зэвсэгт мөргөлдөөний 19-ийг БНХАУ санаачилсаныг баримт гэрчилж байна. Ийм ч учраас манай гаригийн нийт дэвшилт хүчин, хятадын удирдлагын их гүрний дээрэнгүй, жанжлах бодлого, хорт ажил явууллагын эсрэг нэгдсэн чармайлтаар шаргуу тэмцэж байна.

Дэлхий дахинд, түүний дотор империализм, харгислалын энэ удаагийн сөрөг довтолгооны уудам бөгөөд ноцтой нэг талбар болж буй Ази тивд анх тайван, тогтвортой байдлыг нийтийн хүчин чармайлтаар хангах явдал нэн чухал болж байна. Чухамхүү үүнд ЗХУКН-ын XXVI их хурлаас боловсруулсан 80-аад оны энх тайвны программ, Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай Конвенц байгуулах, түүнийг хэрэгжүүлэхийн тулд Ази, Номхон далайн орнуудын бага хурал хуралдуулахаар МАХН-ын XVIII их хурлаас дэвшүүлсэн санаачлага, түүнчлэн Энэтхэг-Хятадын хойгийн ах дүү гурван улс, Ардчилсан Афганистаны засгийн газраас тавьсан оновчтой саналууд захирагдаж байгаа юм.

Эдгээрийг хэрэгжүүлэхийн төлөө Монголын олон нийт энхийг эрхэмлэгч бүх хүчний хамт цуцалтгүй тэмцэх зориг эрмэлзлэл төгс байна.

КИТАЙ: ВОПРОСЫ ВОЙНЫ И МИРА

Р е з ю м е

Начало 80-х годов ознаменовалось ростом напряженности международной обстановки вследствие безответственной, авантюристической политики администрации США и ее союзников по НАТО. Угрозу миру увеличивает и гегемонистический внешнеполитический курс нынешнего китайского руководства.

Острие этой политики направлено против стран социалистического содружества и в первую очередь против Советского Союза-главной сдерживающей силы китайского экспансионизма. Пытаясь столкнуть в междоусобной войне социалистические и капиталистические страны, китайские лидеры намерены претворить в жизнь свои гегемонистические планы.

Военным целям подчинена кампания «4-х модернизаций». Наука и техника в современном Китае поставлены в первую очередь на службу военным нуждам. Китай является единственной в мире страной, которая использует атомную энергию только в военных целях. Не случайно поэтому китайское руководство является противником любых мер по ослаблению международной напряженности и обузданию гонки вооружений, выдвигаемых Советским Союзом и другими социалистическими странами.

Экспансионистские планы Пекина находят свое практическое применение. Мирлюбивая общественность гневно осудила варварскую войну Китая против социалистической республики Вьетнам. Китаем финансируются и находят прибежище банды кровавого полпотовского режима и афганские контрреволюционеры. Китай постоянно нагнетает напряженность на границе с МНР и другими соседними странами. Достаточно сказать, что КНР предъявляет соседним странам территориальные притязания на 10 млн. км².

Монгольский народ хорошо понимает какую опасную роль играет нынешнее пекинское руководство в нагнетании напряженности на Азиатском континенте. Именно ослаблению напряженности в Азии и распространению мер взаимного доверия служит предложение МНР о заключении конвенции о неприменении силы и ненападении между странами Азии и Тихого океана, выдвинутое на XVIII съезде МНРП.